

I маягт

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолын ... дүгээр хавсралт

Дүүргийн Эрүү Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд
/Огноо/ /Газар/

НЭХЭМЖЛЭЛ

/Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа- I маягт/

I. ЗОХИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Нэхэмжлэгч:

Иргэний овог нэр/Хуулийн этгээдийн нэр, зохион байгуулалтын хэлбэр: Баян-Уул ХХК

Оршин суух/байх хаяг: Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө, ТВ5 офисс, 1 давхарт

Иргэний бүртгэлийн дугаар:.....

Хуулийн этгээд бол регистрийн дугаар: 815475х

Цахим шуудангийн хаяг: naranerdene_b@gmail.com

Утасны дугаар: 8000165х

/хэд хэдэн нэхэмжлэгчтэй бол нэхэмжлэгч тус бүрээр дээрх мэдээллийг өгч хавсаргана уу/

Хариуцагч:

Иргэний овог нэр/Хуулийн этгээдийн нэр, зохион байгуулалтын хэлбэр: Сүхбаатар овогтой Наранзул

Оршин суух/байх хаяг: Баянзүрх дүүрэг, 39 дүгээр хороо, Улаанхуаран гудамж, 75Б байр 1х тоот

Иргэний бүртгэлийн дугаар: РД7515203х

Хуулийн этгээд бол регистрийн дугаар:

Цахим шуудангийн хаяг: naranzul_s@gmail.com

Утасны дугаар: 8830754х, 9975421х

/хэд хэдэн хариуцагчтай бол хариуцагч тус бүрээр дээрх мэдээллийг өгч хавсаргана уу/

II. НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГА:

Мөнгөн хөрөнгө гаргуулах /3.1, 3.2, IV, V, VI хэсгүүдэд хариулна уу/

(Таны шаардаж байгаа мөнгөн хөрөнгө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй хэмжээтэй байх ёстой.)

Барьцааны зүйлээс үүргийг хангуулах /3.2, V, VI хэсгүүдэд хариулна уу/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгуулах /3.3, V, VI хэсгүүдэд хариулна уу/

III. МАРГААНЫ АГУУЛГА:**3.1. Хариуцагчаас мөнгөн хөрөнгө гаргуулах болсон үндэслэлийг сонгоно уу.**

- Хариуцагчтай байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу шаардаж байгаа мөнгөн хөрөнгө *(А-1-А-15 маягтаас тохирохыг бөглөнө үү)*
- Дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээний үнэ *(Б-1 маягтыг бөглөнө үү)*
- Хөдөлмөрийн гэрээний дагуу олгоогүй цалин хөлс *(Б-2 маягтыг бөглөнө үү)*
- Эд хөрөнгө, эрүүл мэндэд учирсан гэм хор *(Б-3 маягтыг бөглөнө үү)*
- Ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор *(Б-4 маягтыг бөглөнө үү)*

3.2. Барьцааны зүйлээс үүргийг хангуулах шаардлагын талаар тодруулна уу.

- Мөнгө төлүүлэх ба барьцааны шаардлагыг хамт гаргаж байна. *(А-13 маягтыг бөглөнө үү)*
- Мөнгө төлөх шүүхийн шийдвэрийг өмнө нь гаргуулсан тул барьцааны шаардлагыг дангаар нь гаргаж байна. *(А-13 маягтыг бөглөнө үү)*
- Хариуцагч мөнгө төлөхийг зөвшөөрсөн боловч барьцааг зөвшөөрөхгүй байх тул барьцааны шаардлагыг дангаар нь гаргаж байна. *(А-13 маягтыг бөглөнө үү)*

3.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой дараах шаардлагыг гаргаж байна.

- Хөрөнгийг битүүмжлэх, хураах ажиллагааны талаарх шаардлага *(Б-5 маягтыг бөглөнө үү)*
- Хөрөнгийн үнэлгээ тогтоох ажиллагааны талаарх шаардлага *(Б-6 маягтыг бөглөнө үү)*
- Хөрөнгийг дуудлага худалдаанд оруулах ажиллагааны талаарх шаардлага *(Б-7 маягтыг бөглөнө үү)*

IV. ГЭРЭЭНИЙ МАРГААН: Мөнгөн хөрөнгө гаргуулах болон барьцааны үүргийг шаардах үндэслэл болсон гэрээ нь

- Худалдах-худалдан авах гэрээ *(А-1 маягтыг бөглөнө үү)*
- Зээлийн гэрээ *(А-2 маягтыг бөглөнө үү)*
- Банк ба банк бус санхүүгийн байгууллагын зээлийн гэрээ *(А-3 маягтыг бөглөнө үү)*
- Бэлэглэлийн гэрээ *(А-4 маягтыг бөглөнө үү)*
- Эд хөрөнгө хөлслөх гэрээ *(А-5 маягтыг бөглөнө үү)*

- Түрээсийн гэрээ (А-6 маягтыг бөглөнө үү)
- Санхүүгийн түрээсийн гэрээ (А-7 маягтыг бөглөнө үү)
- Ажил гүйцэтгэх гэрээ (А-8 маягтыг бөглөнө үү)
- Даатгалын гэрээ (А-9 маягтыг бөглөнө үү)
- Мөнгөн хадгаламжийн гэрээ (А-10 маягтыг бөглөнө үү)
- Зуучлалын гэрээ (А-11 маягтыг бөглөнө үү)
- Тээвэрлэлтийн гэрээ (А-12 маягтыг бөглөнө үү)
- Барьцааны гэрээ (А-13 маягтыг бөглөнө үү)
- Хамтран ажиллах гэрээ (А-14 маягтыг бөглөнө үү)
- Бусад гэрээ (А-15 маягтыг бөглөнө үү)

V. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тодруулах асуулт:

5.1. Та хариуцагчийн оршин суугаа хаягийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж байна уу?

- Тийм
- Үгүй

5.2. Нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр байгаа юу?

- Тийм
- Үгүй

5.3. Маргаж байгаа зүйл болон түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа, эсхүл эрүүгийн журмаар шалгаж байгаа юу?

- Тийм
- Үгүй

5.4. Та хариуцагчтай эвлэрэн хэлэлцэх хүсэлтэй юу?

- Тийм
- Үгүй

5.5. Маргааныг эвлэрүүлэн зуучлал, эсхүл арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсон уу?

- Тийм
- Үгүй

5.6. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмаар хуульд заасан байгууллагад хандсан уу?

- Тийм
- Үгүй

VI. Нэхэмжлэлд хавсаргасан баримтын жагсаалтыг хавсаргана уу.

1. Нэхэмжлэл 4 хуудас
2. Улсын тэмдэгтийн хураамж 1 хувь
3. “Баян- Уул” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - 1 хувь

4. Итгэмжлэл 1 хувь
5. С.Мөнхцэцэгийн тайлбар нотариатаар батлуулсан хуулбар - 4 хуудас
6. С.Наранзулын оршин суугаа газрын лавлагааг нотариатаар батлуулсан хуулбар -1 хуудас
7. С.Наранзулын хөдөлмөрийн гэрээг нотариатаар батлуулсан хуулбар - 3

ГАРЫН ҮСЭГ:

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд

/Огноо/

/Газар/

ХУДАЛДАХ-ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ДАГУУ МӨНГӨН ХӨРӨНГӨ ГАРГУУЛАХ ШААРДЛАГА

/Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа-А-1 маягт/

1. Нэхэмжлэлийн шаардлагын дүн: 370.000 төгрөг

(Таны шаардаж байгаа мөнгөн хөрөнгө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй хэмжээтэй байх ёстой.)

1.1. Энэ дүнд:

Үндсэн төлбөр: 370.000 төгрөг

Анз: /алданги, торгууль/ төгрөг

Хохирол: төгрөг

Бусад:..... төгрөг

(Хэрэв та тухайн шаардлагыг гаргаагүй бол харгалзах хэсэгт 0 дүн тавина уу)

2. Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл:

- Худалдсан эд хөрөнгийн үнийг гаргуулах
- Шилжүүлсэн мөнгөө буцаан гаргуулах
- Эд хөрөнгийн доголдлыг арилгахад гаргасан зардал гаргуулах
- Анз гаргуулах
- Учирсан хохирол гаргуулах
- Бусад

3. Дараах асуултад хариулна уу?

3.1. Гэрээг бичгээр байгуулсан уу?

Тийм

Үгүй

3.2. Гэрээний зүйлийг хүлээлцсэн үү?

Тийм

Үгүй /3.3, 3.4, 7-д хариулах шаардлагагүй/

Бүрэн биш

3.3. Гэрээний зүйлийг тохирсон хугацаандаа өгсөн үү?

Тийм

Үгүй

Заримыг

3.4. Гэрээний зүйл дутагдал, доголдолтой байсан уу?

Тийм

Үгүй /8, 9-д хариулах шаардлагагүй/

Зарим нь

3.5. Гэрээний зүйлийн үнийг төлсөн үү?

- Тийм
- Үгүй /6-д хариулах шаардлагагүй/
- Бүрэн биш

3.6. Анз, /алданги, торгууль/ төлүүлэхээр гэрээгээр тохиролцсон уу?

- Тийм
- Үгүй

- 4. Гэрээ байгуулсан огноо:
- 5. Гэрээний үнэ:
- 6. Худалдан авагч үнэ төлсөн огноо:
- 7. Гэрээний зүйлийг хүлээлцсэн огноо.....
- 8. Гэрээний зүйлийн дутагдал, доголдлыг илрүүлсэн огноо:
- 9. Дутагдал, доголдлын талаар нөгөө талдаа мэдэгдсэн огноо:
- 10. Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, үйл баримтын талаар ач холбогдолтой гэж үзсэн нөхцөл байдлын талаар 300 үгэнд багтаан бичнэ үү.
- 11. Хавсаргасан баримтыг жагсаана уу.

Нэхэмжлэгч “Баян-Уул” ХХК нь Сүхбаатар овогтой Наранзул /РД:РД7515203х/-д холбогдуулан дараах нэхэмжлэлийг гаргаж байна.

С.Наранзул нь 2024 оны 03-р сарын 05-ны өдөр “Баян-Уул” ХХК-д Худалдааны төлөөлөгч ажилтнаар ажилд орсон. С.Наранзулын ажил үүргийн хуваарь нь хүнсний дэлгүүр, харилцагчид компанийн бараа бүтээгдэхүүнийг танилцуулж, захиалга авах ERP программын эрхээр нэвтрэн орж захиалга авах, харилцагчийн нэр дээр бараа шивэх зэрэг ажил үүрэг эрхэлдэг байсан. С.Наранзул нь ажиллаж байх хугацаандаа байгууллагын харилцагчид хүргэсэн бараа бүтээгдэхүүнийн төлбөрийг хувьдаа авч завших зөрчил гаргаж байгууллагад хохирол учруулсан. Тухайлбал: 2024.03.07-ны өдөр “Наран Ургах” хүнсний дэлгүүрт 370,000 төгрөгийн үнийн дүнтэй электрон тамхи нийлүүлсэн боловч нийлүүлсэн барааны төлбөрийг хувьдаа авч завшсан үйлдэл гаргасан. Иймд С.Наранзулаас байгууллагад төлөх төлбөр 370,000 /гурван зуун далан мянга/ төгрөгийг, улсын тэмдэгийн хураамжийн хамт гаргуулан өгнө үү.

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСАН: